



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/171

Бат-Өлзий сум

Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ой бүхий 16000 га талбайд “Гранд Форест”, “Аглаг ой” хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд ойн хортон шавж устгалын ажлыг авиа микробиологийн аргаар “Эйр-трактор” онгоц Цагаан азарга, Бөөрөг, Хүрдэт, Уурагт, Уньт, Хоргой хүрэм, Хятруун, Битүүт, Ар булаг, Ангилаг, Байц, Улаан, Улаан ам, Хийн ам, Мухдаг, Мөст, Хөнөг, Хүүхдийн асга, Төмөрт, Хамар, Бугат, Их мойлт, Бөхөн шар, Төвхөн, Нарийн, Билүүт, Гурван бадай, Дээд ар жалга, Дунд ар жалга, Доод ар жалга, Хурц, Бугат, Их булаг, Шивэртий, Ямаат, Торго, гэх ой бүхий газруудад 2023 оны 08 дугаар сарын 11-ээс 2023 оны 08 дугаар сарын 21 хүртэлх хугацаанд хорио цээр тогтоосугай.

2. Хорио цээр тогтоосон ойн сан бүхий газарт иргэд, гадаад, дотоодын аялагч, мал оруулахгүй байхыг малчид, аялагч нарт сурталчлан ажиллахыг Багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, С.Төмөр, Д.Бямбасүрэн, Д.Дэмиддагва, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сум дундын ойн анги, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Янжиндулам, Байгаль хамгаалагч (Ж.Батмөнх, Б.Энхмаа), Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч (Х.Чулуунбат, М.Мөнхдалай, Ш.Баасансүрэн, Б.Цэдэнбал, Ц.Төмөрхуяг) нарт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ



27301349